СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: Б.Мөнхбамбар
Утас: 70512127 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн орлогын тайлан 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
3. Аудитын тайлан 7
3.1 Ерөнхий зүйл 7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 8
3.4 Материаллаг байдал 8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга 9
Байгууллагын үйл ажиллагаа 9
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин 9
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого 9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 11
3.8 Аудитын гол асуудал 11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 12
4. Аудитын илрүүлэлт 12
4.1 Төлбөрийн акт 12
4.2 Албан шаардлага 12
4.3 Зөвлөмж 12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Аудитын санал дүгнэлт

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.18 № 145

танай _____-ны №_____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ИЙН ЗАХИРАЛ
Х.БААТАРСҮХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Данс ны код	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
А	Б		1	2
1	**ХӨРӨНГӨ**		*	*
1.1	**Эргэлтийн хөрөнгө**		*	*
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		19,188,432.31	18,329,766.26
1.1.1.2	Банкин дахь мөнгө	1101	19,188,432.31	18,329,766.26
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		36,680,931.72	34,367.71
1.1.3.1	НӨАТ-ын тооцоо	1206	36,675,574.02	0.00
1.1.3.6	ЭМНД-ийн шимтгэлийн тооцоо	1210	5,357.69	34,367.71
1.1.4	Бусад авлага		12,399.47	40,121,111.21
1.1.4.1	Хувь хүнээс авах авлага	1201	12,399.47	20,056.00
1.1.4.2	Байгууллагаас авах авлага	1202	0.00	40,101,055.21
1.1.6	Бараа материал		119,502,242.20	118,899,158.58
1.1.6.4	Хангамжын материал	1501	108,288,433.13	104,976,622.23
1.1.6.5	Сэлбэг хэрэгсэл	1502	11,213,809.07	13,922,536.35
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		172,923.63	1,543,311.60
1.1.7.2	Урьдчилж төлсөн түрээс, даатгал	1602	172,923.63	1,543,311.60
	Эргэлтийн хөрөнгийн дүн		**175,556,929.33**	**178,927,715.36**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**			
1.2.1	Үндсэн хөрөнгө		8,448,684,540.55	7,175,893,857.25
1.2.1.2	Барилга байгууламж	2001	5,322,625,248.99	5,322,625,248.99
1.2.1.3	Хуримтлагдсан элэгдэл. Барилга	2011	-1,136,574,361.66	-1,705,604,274.81
1.2.1.4	Машин, тоног төхөөрөмж	2002	21,034,570.68	25,498,207.04
1.2.1.5	Хуримтлагдсан элэгдэл. МТТ	2012	-11,126,940.56	-13,373,575.14
1.2.1.6	Тээврийн хэрэгсэл	2003	480,818,300.00	458,168,300.00
1.2.1.7	Хуримтлагдсан элэгдэл. Тээвэр	2013	-371,217,980.56	-316,237,605.56
1.2.1.8	Тавилга эд хогшил	2004	10,174,015.00	10,932,105.91
1.2.1.9	Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	2014	-8,268,034.00	-9,533,132.96
1.2.1.10	Компьютер, бусад хэрэгсэл	2005	13,839,190.00	13,839,190.00
1.2.1.11	Хуримтлагдсан элэгдэл. Компьютер	2015	-6,358,634.45	-9,786,967.79
1.2.1.12	Бусад үндсэн хөрөнгө	2006	7,313,732,401.53	7,313,732,401.53
1.2.1.13	Хуримтлагдсан элэгдэл. БҮХ	2016	-3,179,993,234.41	-3,914,366,039.96
1.2.2	Биет бус хөрөнгө		166,369,000.00	166,369,000.00
1.2.2.13	Бусад биет бус хөрөнгө	2107	166,369,000.00	166,369,000.00
1.2.1	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**		**8,615,053,540.55**	**7,342,262,857.25**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**		**8,790,610,469.89**	**7,521,190,572.60**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ**			
2.1	**ӨР ТӨЛБӨР**			
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**			
2.1.1.1	Дансны өглөг		8,113,045.00	8,113,045.00
2.1.1.1.1	Бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг	3106	8,113,045.00	8,113,045.00
2.1.1.2	Цалингийн өглөг	3105	28,850.00	14,249.71
2.1.1.3	Татварын өр		40.00	6,612,193.35
2.1.1.3.1	НӨАТ-ын тооцоо	1206	0.00	6,591,617.30
2.1.1.3.3	ХХОАТ-ын тооцоо /Суутган-1/	1208	40.00	20,576.05
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3206	9,096,689,440.24	7,900,152,273.94

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3209	10,681,000.00	10,681,000.00
2.1.1.1.1	Байгууллагад өгөх өглөг	3101	10,681,000.00	10,681,000.00
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**		**9,115,512,375.24**	**7,925,572,762.01**
2.1.2.10	**Өр төлбөрийн нийт дүн**		**9,115,512,375.24**	**7,925,572,762.01**
2.3	**2. Эзэмшигчийн өмч**			
2.3.1	Төрийн өмч	4101	4,332,924,228.00	4,332,924,228.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		4,942,238,332.33	4,942,238,332.33
2.3.6.1	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	4106	4,942,238,332.33	4,942,238,332.33
2.3.9	Хуримтлагдсан ашиг:		-9,600,064,465.68	-9,679,544,749.73
2.3.9.1	Тайлант үеийн ашиг	4112	0.00	-42,109,411.87
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	4113	-9,600,064,465.68	-9,637,435,337.85
2.3.11	**Эздийн өмчийн дүн**		**–324,901,905.36**	**–404,382,189.40**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**		**8,790,610,469.89**	**7,521,190,572.60**

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт		2020 ОНЫ 12 САРЫН 31	2021 ОНЫ 12 САРЫН 31
1	**Борлуулалтын орлого (цэвэр)**		**40,633,264.60**	**27,414,124.55**
1.1	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	5101	40,633,264.60	27,414,124.55
3	**Нийт ашиг /алдагдал/**			**27,414,124.55**
4	Түрээсийн орлого	5103	4,327,272.73	4,006,818.18
5	Хүүний орлого	5104	114,472.97	0.00
8	Бусад орлого		1,867,435,698.09	2,360,605,187.46
	Бусад орлого	8401	102,328,586.36	409,017,592.54
	Үйл ажиллагааны бус орлого	8403	1,241,303,346.73	1,239,926,122.10
	Санхүүжилтийн орлого	8406	523,803,765.00	711,661,472.82
9	Борлуулалт, маркетингийн зардал		529,420,652.07	955,380,728.86
-	Ажиллагчдын цалингийн зардал	7001	276,557,116.48	333,838,505.16
-	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	7002	39,636,592.96	49,924,396.56
-	Албан татвар, төлбөр, хураамж	7003	546,700.00	597,283.00
-	Томилолтын зардал	7004		212,000.00
-	Сургалтын зардал	7008	79,000.00	0.00
-	Даатгалын зардал	7010	621,842.85	880,200.00
-	Ашиглалтын зардал	7011	126,160.00	2,659,401.00
-	Түрээсийн зардал	7014		89,277,090.91
-	Тээврийн зардал	7017		650,000.00
-	Шатахууны зардал	7018	69,534,599.45	154,418,478.49
-	Бусад зардал	7021	142,318,640.33	322,923,373.74
10	Ерөнхий ба удирдлагын зардал		1,448,716,450.89	1,452,409,641.39
-	Ажиллагчдын цалингийн зардал	7001	29,177,682.44	43,275,771.39
-	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	7002	4,230,763.95	6,678,212.58
-	Албан татвар, төлбөр, хураамж	7003	637,640.00	577,720.00
-	Томилолтын зардал	7004		584,000.00
-	Бичиг хэргийн зардал	7005	1,083,786.09	923,563.20
-	Шуудан холбооны зардал	7006	745,234.40	658,903.98
-	Мэргэжлийн үйлчилгээний зардал	7007		30,205,037.00
-	Сургалтын зардал	7008	21,000.00	0.00
-	Даатгалын зардал	7010	5,997.15	0.00
-	Ашиглалтын зардал	7011	14,153,198.05	14,434,717.61
-	Элэгдэл, хорогдлын зардал	7013	1,343,730,729.43	1,327,912,410.57
-	Шатахууны зардал	7018	12,521,077.02	19,727,661.96

-	Хүлээн авалтын зардал	7019	20,119.00	0.00
-	Зар сурталчилгааны зардал	7020	2,545,454.55	0.00
-	Бусад зардал	7021	39,843,768.81	7,431,643.09
12	Бусад зардал /ҮАБЗ/		1,830,010.96	26,345,171.81
-	Хандивын зардал	8701	317,240.00	300,000.00
-	Торгууль алдангийн зардал	8702	171,570.96	17,532,646.90
-	Үйл ажиллагааны бус зардал	8705	1,341,200.00	8,512,524.91
-	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	8410	295,454.55	0.00
-	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	8710	-317,947.92	0.00
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**		-67,478,898.90	-42,109,411.87
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**		-67,478,898.90	-42,109,411.87
22	**Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/**		-67,478,898.90	-42,109,411.87
24	**Орлогын нийт дүн**		-67,478,898.90	-42,109,411.87

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2020 оны 12 сарын 31 үлдэгдэл**	**4,332,924,228.00**	**4,942,238,332.33**	**-9,600,064,465.68**	**-324,901,905.36**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-37,370,872.17	**-37,370,872.17**
3	**Залруулсан үлдэгдэл**	**4,332,924,228.00**	**4,942,238,332.33**	**-9,637,435,337.85**	**-362,272,777.53**
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/			-42,109,411.87	**-42,109,411.87**
5	Бусад дэлгэрэнгүй орлого		0.00		**0.00**
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00			**0.00**
7	Зарласан ногдол ашиг			0.00	**0.00**
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		0.00		**0.00**
9	**2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл**	**4,332,924,228.00**	**4,942,238,332.33**	**-9,679,544,749.73**	**-404,382,189.40**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөр дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	**1,153,279,506.40**
	1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	29,467,437.00
	1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	711,661,472.82
	1.1.6 Бусад мөнгөн орлого	412,150,596.58
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,138,494,272.45
	1.2.1 Ажилчдад төлсөн	311,164,268.61
	1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	100,875,000.00
	1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	234,436,303.32
	1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	16,204,530.47
	1.2.5 Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	167,338,196.80
	1.2.7 Татварын байгууллагад төлсөн	42,878,975.54
	1.2.8 Бусад мөнгөн зарлага	265,596,997.71
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	14,785,233.95
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	600,000.43
	2.1.5 Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	600,000.43
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	16,243,900.43
	2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	15,643,900.00

	2.2.5 Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	600,000.43
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ**	-15,643,900.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	60,000.00
	3.1.1 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	60,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**60,000.00**
	3.2.1 Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	60,000.00
4.1	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	-858,666.05
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	19,188,432.31
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	18,329,766.26

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өр төлбөр, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ статустайгаар төрийн 100 хувийн өмчлөлтэй, Баруун-Урт суманд харьяалагдаж, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн эд аж ахуйн ашиглалт, хамгаалалтыг хариуцаж, түүнд учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх
- Орчны ариун цэврийг сахиулж, эрүүл орчин бий болгож, хог хаягдлыг ил задгай хаяхаас сэргийлэх
- Өвлийн улиралд аймгийн төвийн гудамж талбай, замын цас, мөсний цэвэрлэгээг тогтмол хийх
- Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах болон түүхий эдийн эх үүсвэр болгон дахин ашиглах

- Хог хаягдлын төлбөрийг иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс хураан авч, өөрийн үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулах
- Золбин муур, нохойн устгал хийх
- Ландфиллийн арга технологиор тохижуулсан аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгийн эмх цэгцийг алдагдуулалгүй хогийг заасан цэгүүдэд хаях, бусад иргэн байгууллагаас тээвэрлэн ирсэн хог хаягдалд хяналт тавьж, харуул манаачийг ажиллуулах
- Мал, туслах аж ахуйн амьтдыг хориглосон цэгт оруулахгүй, ногоон байгууламж устгах, хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх
- Гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбай, явган замын эвдрэлийг засварлах
- Хөл газрын ургамлын харшлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэх хотын тохижилтод өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор шарилжийг тухай бүр нь тогтмол устгах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 2,434.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 24.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн зорилго нь Хог хаягдлын менежментийг сайжруулж, Баруун-Урт сумын иргэдийг эрүүл аюулгүй, цэвэр орчинд ая тухтай ажиллаж, амьдрах боломж нөхцөлийг бүрүүлэхэд үндсэн зорилт оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, засвар арчлалт гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд автозам, замын байгууламжийг засвар арчлалт статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2018 оны 163 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд бүртгэл, хяналтыг сайжруулахаар 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинэ тоног төхөөрөмж худалдан авах тусгасан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй боловч чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоогоор 64 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулахаас 51 орон тоотой явуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 1.0 сая төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19.2	18.3	-0.9
Авлага	36.7	40.1	3.4
Урьдчилгаа	0.2	1.5	1.3
Бараа материал	119.5	118.9	-0.6
Үндсэн хөрөнгө	8,448.7	7,175.9	-1,272.8
Биет бус хөрөнгө	166.4	166.4	0.0
Нийт хөрөнгийн дүн	**8,790.6**	**7,521.2**	**-1,269.4**
Өр төлбөрийн дүн	9,115.5	7,925.6	-1,189.9
Богино хугацаат өглөг	9,115.5	7,925.6	-1,189.9
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	-324.9	-404.4	-79.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**8,790.6**	**7,521.2**	**-1,269.4**

Харилцах дансны үлдэгдэл 18.3 сая төгрөг болж 0.9 сая төгрөгөөр буурсан байна.

Авлагын үлдэгдэлд 40.1 сая төгрөг болж 3.4 сая төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангаас “Хог хаягдлын менежментийг сайжруулах” төслийн хүрээнд хийгдсэн ажлын үлдэгдэл санхүүжилтийг авлагаар тусгасан нь нөлөөлсөн байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 40.1 сая төгрөгийн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 118.9 сая төгрөг болж 0.6 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд худалдан авалтаар 361.4 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд шинээр 15.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, 40.0 сая төгрөгийн хөрөнгө Баруун-Урт сумын Засаг даргын 2021 оны А/63 дугаар тогтоолоор үнэ төлбөргүй дансанд бүртгэж, 72.5 сая төгрөгийн хөрөнгийн аймгийн ИТХ-ын 2021 оны .... дугаар тогтоолоор акталж, хөрөнгө элэгдлийн зардлаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 7,925.6 сая төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 1,189.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн урьдчилж орсон орлого байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 23% буюу 454.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангаас “Хог хаягдлын менежментийг сайжруулах” төслийн ажлууд авч гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3.20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 429.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Азийн

хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангаас “Хог хаягдлын менежментийг сайжруулах” төслийн зардал, үйл ажиллагааны бус зардал 24.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн төлбөр болох 17.5 сая төгрөг барагдуулсан нь шалтгаалжээ.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 01 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,942.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,056.7 сая төгрөгөөр, 114.6 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 2,392.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,434.1 сая төгрөгийн зардал гарган, 42.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,392.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 449.9 сая төгрөг буюу 23 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,434.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 449.9 сая төгрөг буюу 23 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр алдагдал 42.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 72.5 сая төгрөгөөр ашигтай гарсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгч бүрэн биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын тайлант оны үйл ажиллагаа, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 37.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 18.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 18.8 сая төгрөгийн 2 асуудалд зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ойн арга хэмжээнд 0.3 сая төгрөгийн хандив олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 25 дугаар зүйлийн 25.10 /Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно/ дахь заалт болон эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2 Албан шаардлага

Батлагдсан хөрөнгөөр 8.6 сая төгрөгийг баяр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээнд, 9.9 сая төгрөгийг суудлын авто машин худалдан авч төсвийн хэмнэлтийн горимыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;/, 1.6 /Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;/ дахь заалтыг зөрчсөн байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

1.1. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах

дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

2. Өр төлбөр холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тайлант онд 18.8 сая төгрөгийн өр төлбөрийг үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж,/ дагуу өр төлбөрийн тооцоо нийлж баталгаажуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	4	37.6	-	-	1	0.3	1	18.5	2	18.8
Дүн		4	37.6	-	-	1	0.3	1	18.5	2	18.8